



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогтцэций сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: *ӨМА-2023/14/НА-СТА-ТТЗ*

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал
Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 268

танай _____ -ны № _____ -т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г.БАЦМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогтцэций сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогтцэций сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 411.6 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Татварын орлогын төлөвлөгөөг 6,411.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020358

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,625,399.4	6,608,980.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,791,936.1	5,619,818.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	328,036.2	36,548.7
УРЬДЧИЛГАА	7а, 7б	9,259.2	1,866.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,447,852.0	897,424.9
НӨӨЦИЙН БАРАА	9а	48,316.0	53,321.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		32,997,183.6	18,306,469.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	32,997,183.6	18,306,469.6
Биет хөрөнгө		31,263,249.2	16,858,831.9
Биет бус хөрөнгө	13	1,733,934.4	1,447,637.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		36,622,583.0	24,915,449.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,356,878.0	4,574,644.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	232,737.2	421,180.4
Өглөг	17а, 17б	232,737.2	421,180.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		3,124,140.8	4,153,464.0
Урт хугацаат зээл	20а, 20б	3,124,140.8	4,153,464.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		33,265,705.0	20,340,805.5
Засгийн газрын хувь оролцоо		33,265,705.0	20,340,805.5
Засгийн газрын оруулсан капитал		9,605,931.8	6,215,708.7
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		9,605,931.8	6,215,708.7
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	350,994.0
Хуримтлагдсан үр дүн		22,723,078.0	13,614,472.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		936,695.3	159,630.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		36,622,583.0	24,915,449.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		16,884,234.3	38,333,315.6
ТАТВАРЫН ОРЛОГО		2,559,632.3	31,551,099.6
Орлогын албан татвар		626,683.0	19,545,971.2
Хувь хүний орлогын албан татвар		626,683.0	19,731,150.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-185,179.5
Хөрөнгийн албан татвар		1,282.0	7,938,581.2
Бусад татвар, төлбөр, хураамж		1,931,667.3	4,066,547.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,597,010.3	5,838,455.20
Нийтлэг татварын бус орлого		4,597,010.3	5,746,169.30
Хөрөнгийн орлого		0.0	92,285.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,727,591.7	943,760.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	15,165,730.2	30,640,510.7

УРСГАЛ ЗАРДАЛ		15,165,730.2	30,640,510.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,539,741.8	5,547,142.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,303,782.9	538,168.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		577,754.4	70,973.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		468,431.7	647,493.8
Хангамж, бараа материалын зардал		646,521.4	310,693.7
Нормативт зардал		1,446,055.2	2,160.0
Эд хогшил, урсгал засварын зардал		71,098.8	181,167.8
Томилот, зочны зардал		2,754.0	2,307.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		704,132.1	1,148,037.4
Бараа үйлчилгээний бусад зардал		2,319,211.3	2,646,140.4
ТАТААС		0.0	264,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,625,988.4	24,829,368.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,718,504.1	7,692,805.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		351,569.4	253,640.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,366,934.7	7,439,164.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,322,641.1	0.0	26,322,641.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,576,129.2	0.0	5,576,129.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,898,770.4	0.0	31,898,770.4
Тайлант үеийн үр дүн	1,366,934.7	0.0	1,366,934.7
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,265,705.0	0.0	33,265,705.0
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	33,265,705.0	0.0	33,265,705.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-20,364,064.2	0.0	-20,364,064.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,901,640.8	0.0	12,901,640.8
Тайлант үеийн үр дүн	7439164.6	0.0	7,439,164.6
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	20,340,805.5	0.0	20,340,805.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	14,137,073.3	34,677,282.20
ТАТВАРЫН ОРЛОГО	2,559,632.3	31,551,099.6
Орлогын албан татвар	626,683.0	19,545,971.2
Хувь хүний орлогын албан татвар	626,683.0	19,731,150.7

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-185,179.5
Хөрөнгийн албан татвар	1,282.0	7,938,581.2
Бусад татвар, төлбөр, хураамж	1,931,667.3	4,066,547.1
Бусад нийтлэг төлбөр, хураамж	513,588.8	458,010.0
Газрын төлбөр	1,383,494.8	3,591,826.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,583.7	16,711.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,991,620.1	2,182,421.80
Нийтлэг татварын бус орлого	1,991,620.1	2,090,135.80
Хөрөнгийн орлого	0.0	92,285.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,585,820.9	943,760.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,695,197.0	29,236,413.2
УРСГАЛ ЗАРДАЛ	12,695,197.0	29,236,413.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,059,753.7	3,970,686.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,643,279.3	892,503.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	695,661.1	181,945.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,863.7	647,493.8
Хангамж, бараа материалын зардал	803,888.1	663,708.2
Нормативт зардал	495,655.5	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	108,909.4	185,433.0
Томилолт, зочны зардал	2,754.0	2,307.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	645,012.8	1,180,786.4
Бараа үйлчилгээний бусад зардал	206,729.8	216,509.4
ТАТААС	0.0	264,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,635,443.3	25,001,726.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,441,876.2	5,440,869.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,267,347.3	1,612,986.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,267,347.3	1,612,986.3
Дотоод эх үүсвэрээр	1,267,347.3	1,612,986.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,267,347.3	-1,612,986.3
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	174,528.9	3,827,882.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,617,407.2	1,791,936.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,791,936.1	5,619,818.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,335,009.6	4,625,169.0
УРСГАЛ ЗАРДАЛ	4,948,215.6	3,161,214.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,147,981.4	2,675,844.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,358.9	540,068.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,843.1	70,403.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	761,414.7	647,493.8
Хангамж, бараа материалын зардал	104,587.7	94,788.3
Эд хогшил, урсгал засварын зардал	198,812.8	185,433.0
Томилолт, зочны зардал	9,920.0	2,307.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,055,386.9	1,015,124.6
Бараа үйлчилгээний бусад зардал	347,657.3	120,224.4
ТАТААС	264,000.0	264,000.0

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	264,000.0	264,000.0
ШИЛЖҮҮЛЭГ	1,536,234.2	221,370.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,479,966.6	170,572.2
Бусад урсгал шилжүүлэг	56,267.6	50,798.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,386,794.0	1,463,954.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,335,009.6	5,347,425.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	847,316.6
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,483,742.3	4,454,596.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	851,267.3	45,511.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	761,267.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,483,523.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,262.0
УРСГАЛ ЗАРДАЛ	99,262.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,817.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал	68,817.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,444.2
Бусад урсгал шилжүүлэг	9,460.8
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	983.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,444.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	96,444.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(2,817.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(2,817.7)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,704.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 285.4 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого 259.5 сая төгрөгийг татварын бус орлогоор тайлагнасан, үндсэн хөрөнгийн тайланд тайлант оны элэгдлийн зардлыг 25.9 төгрөгөөр зөрүүтэй тусгасан алдааг тус тус залруулсан.

Аудитаар нийт 1,418.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,414.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

5.2 Албан шаардлага

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албаны актын төлбөр 1.6 сая төгрөгийг ОНХС-ийн данснаас төлж, авлага дансанд тусгаагүй, Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад 3.5 сая төгрөгийн бэлэг худалдан авсан, Сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 6/1 тогтоолоор зураг төсөв нь хийгдээгүй 1,409.2 төгрөгийн 11 төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зэрэг нийт 1,414.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Засаг даргын нөөц сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүн эмнэлгийн авто машины засварт 1.3 сая, Мотокроссын уралдаанд 3.0 сая төгрөгийг хүсэлт, тооцсон төсөвгүй олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг хууль, журмын дагуу баримт бүрдсэн үед олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цогтцэций Засаг дарга	2	285.3			2	285.3	2	285.3				
Дүн	2	285.3			2	285.3	2	285.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цогтцэций Засаг дарга	2	5.9			1	1.6	1	4.3				
Дүн	2	5.9			1	1.6	1	4.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Цогтцэций Засаг дарга	2	1,412.7					2	1,412.7				
Дүн	2	1,412.7					2	1,412.7				
Нийт дүн	4	1,418.6					3	1,414.3	1			4.3